

Ардчилал ба хөгжлийн асуудал

Аюурзанын Цанжид, доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс, tsanjid@mas.ac.mn
<https://orcid.org/0009-0003-8562-0355>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-23

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

*хөгжлийн стратеги,
“дөрвөл” загвар, бүх
нийтийн зөвшилцөл,
төлөөлөл,
өрсөлдөөн,
популизм, төрд
итгэх итгэл,
сонгуулийн
тогтолцоо*

Хураангуй: Хүн төрөлхтөн технологийн үсрэнгүй хөгжлөөр жолоодуулсан хөгжлийнхөө шинэ үеийн хаалгаар орж байна. Улс орнууд инновац, тэргүүний технологид суурилан хөгжил дэвшлээ түргэсгэхийн төлөө үндэсний чадамжаа бүрэн дүүрэн дайчлах оролдлого хийж байна. Үүний тулд богино хугацаанд хөгжсөн орнуудын туршлагаар “гүйцэх” стратегийг баримталж байна. Монгол орны хувьд ийм “гүйцэх” юм уу “утгах” маягийн стратегийг хэрэгжүүлэх боломжтой юм. Зохиогч өмнөх бүтээлдээ хөгжлийн “дөрвөл” загварыг боловсруулан санал болгосон юм. Түүнийг хэрэгжүүлэхэд улс орны боломжийг бүрэн дайчлан ашиглах шаардлагатай. Ардчиллын нөхцөлд ийнхүү нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглахад бүх нийтийн зөвшилцөлд тулгуурласан бодлого, үйл ажиллагаа чухал юм. Бүх нийтийн зөвшилцлийн улс төрийн суурь дэвсгэр нь парламент сонгогчдын бүхий л хэсгийн ашиг сонирхлыг тусгасан өргөн төлөөлөлтэй байх явдал юм. Ардчиллын үйл явц эхэлж байх үед Монгол улсад мажоритар тогтолцоо илүү зохистой байхаар байсан бол, өнгөрсөн жилүүдэд нөхцөл байдал өөрчлөгдөж, сонгогчдын байр суурь, сонирхол олон янз болсон ба шинэ үеийн сонгогчид гарч ирэв. Нөгөө талаас мажоритар тогтолцоо нь сонгогчдын нэлээд хэсгийг УИХ -д төлөөлөлгүй үлдээх боловч. МАН болон АН -аас бусад намуудын авч байгаа санал өсөж, хорин хувийг давах болсон боловч УИХ -д суудал эзэлж чадахгүй шахам байгаа юм. Энэ бүхэн төлөөллийн ардчилал бүхий тус улсын хувьд шударга бус юм. Түүнээс гадна мажоритар тогтолцоо нь иргэдийг хоёр хэсэгт хуваах, талцал, үзэн ядалтыг нэмэгдүүлэх хандлагатай байдгийг дэлхийн туршлага харуулж байна. Ардчиллын нөхцөлд улс төрийн өрсөлдөөн зайлшгүй боловч, өрсөлдөөн хэт туйлших нь популизм зэрэг сөрөг үзэгдлийг гааруулах, улмаар төр засагт итгэх иргэдийн итгэлийг бууруулах сөрөг талтай юм. Үүнийг мажоритар тогтолцоотой АНУ, Англи болон хувь тэнцүүлэх тогтолцоо давамгайлдаг Европын судлаачдын аль алины нь судалгааны дүгнэлт харуулж байна. Хөгжлийн төлөөх бүх нийтийн зөвшилцлийн эрх ашиг, иргэдийн бүх хэсгийн төлөөллийг хангах, улс төрийн өрсөлдөөнийг эрүүл саруул болгохын тулд УИХ -ыг сонгуулийг хувь тэнцүүлэх тогтолцоогоор явуулах шаардлагатай болсон байна.

Keywords
*democracy,
development,
majoritarian,
catch-up parties,
parliament*

Democracy and developmental issues

Tsanjid Ayurzana (Sc.D), Professor
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia, tsanjid@mas.ac.mn
<https://orcid.org/0009-0003-8562-0355>

© The Author(s), 2024



Abstract: Humanity is entering a new era driven by the rapid development of technology. Countries are trying to fully mobilize their national capabilities to accelerate their development based on innovation and advanced technologies. For this purpose, they follow the “Catch-up” strategy based on the experience of Asian countries that have developed in a short period of time. For Mongolia, it is possible to implement such a strategy of “catch-up” or “accommodation”. In his previous work, the author proposed the “quartet” model of development. To implement it, it is necessary to use the full potential of the country. In a democratic environment, policies and activities based on universal consensus are important for the full use of these resources. The political basis of broad consensus is that parliaments should be broadly representative, reflecting the interests of all sections of the electorate. At the beginning of the democratization process, the majoritarian system was more appropriate in Mongolia, but in recent years, the situation has changed, the positions and interests of voters have varied, and a new generation of voters has appeared. On the other hand, recently, the majoritarian system has left a large part of the electorate without representation in the parliament. The number of votes received by parties other than MPP and DP has increased and exceeded 20%, but they are almost unable to win seats in the Parliament. All this is unfair for a country with a representative democracy. Moreover, world experience shows that majoritarian systems tend to divide citizens into two groups and increase bias and hatred. Political competition is inevitable in a democracy, but extreme competition can lead to negative phenomena such as populism and thus reduce the confidence of the people in the government. This is shown by the research findings of researchers in the United States and England, which have a majoritarian system, and Europe, where the proportional system prevails. In order to ensure the interests of the general consensus for development, to ensure the representation of all sections of the citizens, and to make political competition healthy, it is necessary to conduct the elections of the Parliament on a proportional system.

I. Оршил

Манай орон улс төрийн амьдралыг ардчилах, эдийн засагт зах зээлийн зарчмыг нэвтрүүлэх зорилтыг амжилттай хэрэгжүүлж байгаа билээ. Үүгээрээ ч дэлхийн хөгжиж байгаа орнуудад үлгэр жишээ болж байгаа хэмээн үнэлэгдэж ирлээ. Гэвч улсын эдийн засгийн өсөлт төдийлөн их бус, өсөлтийн үр шимийг иргэд хүртэж чадахгүй байгаа болон нийгэмд баян

хоосны ялгаа гарч, улам бүр ихсэж байгаа нь санаа зовоох асуудал болж байна. Улс төр, төрийн захиргааны хүрээнд авлига нэмэгдэж, улс төрчид, захиргааны ажилтнуудын ёс зүй доройтсон, сонгуулийн будилаан, популизм зэрэг сөрөг үзэгдэл ихэссэн нь нийгэмд дургүйцэл буй болгож, ардчиллын нэр хүндийг иргэдийн дунд унагаж, зарим талаар социализмын үеийг эргэн санагалзах уур амьсгалыг

буй болгож байна. Улс орноо хөгжүүлэх талаар удаа дараа бодлогын баримт бичиг гарч байсан боловч тэдгээрийг тогтвортой мөрдөхгүй өөрчилж ирсэн нь хөгжлийн тогтсон үзэл баримтлалгүй болгож байна.

Гэтэл дэлхий дахинд аж үйлдвэрийн шинэ шинэ хувьсгал өрнөж, улс орон бүр шинжлэх ухаан, технологийн ололтод түшиглэн хөгжихийг эрмэлзэн, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд инновац хийж байна.

Энэхүү өгүүллийг бичигч миний бие 2023 онд бичсэн бүтээлдээ (Цанжид А. 2023) шинжлэх ухаан, технологийн хөгжилд суурилсан хөгжлийн дөрвөл загварын талаар санал дэвшүүлсэн билээ. Саналын гол цөм бол өмнө хөгжсөн улс орнуудын болон одоо эрчимтэй хөгжиж буй орнуудын баримталж буй хөгжлийн төрийн үзэл санаа юм. Дөрвөл загварын агуулга нь ШУТИ-д тулгуурласан

хөгжлийн тодорхой зорилго бүхий үзэл баримтлалыг боловсруулан нийт нийгмийн зөвшилцөлд тулгуурлан, улсын бүхий л боломж чадавхыг дайчлан богино хугацаанд хөгжих боломжтой хэмээх үзэл санаагаар илэрнэ. Тэрхүү загварыг дараах бүдүүвчээр дүрслэн харуулав. Энэхүү загварт төр, шинжлэх ухаан, бизнес, иргэний нийгмийн бодлого, үйл ажиллагааг нэгтгэн зангидаж, шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээг эрчимжүүлэх, дэвшилттэй технологийг үйлдвэрлэл, үйлчилгээ болон нийгмийн амьдралын бусад салбарт нэвтрүүлэх замаар хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх тухай санааг тусгасан юм. Үүнтэй төстэй загвараар улс орноо богино хугацаанд хөгжүүлсэн болон эрчимтэй хөгжүүлж байгаа туршлага байгаа нь энэхүү үзэл санааг манай орны хувьд ч хэрэгжүүлэх боломж байгааг харуулж байгаа болно.

Зураг 1. Хөгжлийн дөрвөл загвар



Шинжлэх ухаан, технологи, инновацад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн судалгаа, шинжилгээний

ажлын үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх нь янз бүрийн сонирхлын уулзвар дээр, зөрчил

сөргөлдөөний нөхцөлд хийдэг амаргүй ажил юм. Энэ явцад хожигсад ба хохирогсад гарах бөгөөд хэрэгжүүлж чадсан нөхцөлд нийтээрээ түүний үр дүнг хүртдэг. Хөгжлийн төрийн үзэл санааг хэрэгжүүлсэн орнуудын нэлээд хэсэг нь захиргаадгалтын юм уу эсвэл ардчиллын хүрээ хязгаар ямар нэг хэмжээгээр хумигдсан нөхцөлд амжилт олсон байдаг.

Тийм учраас хөгжлийн дөрвөл загварыг ардчиллын нөхцөлд, бүр тодорхой яривал манай оронд хэрэгжүүлэх боломж бий юү гэдэг асуулт гарч байгаа юм. Тийм боломж бий хэмээн үзэж байгаа учраас энэхүү асуултад “тийм” гэсэн хариулт өгч, дөрвөл загварыг дэвшүүлж байгаа юм. УИХ -ын 2024 оны сонгуулийн үр дүнгээр хамтарсан засгийн газар байгуулагдан ажиллаж эхэлсэн нь ийм бүх нийтийн зөвшилцөл буй болгох урьдач нөхцөл манай оронд байгааг харуулж байна.

Дөрвөл загварт хамрагдаж байгаа салбар бүрийн бодлого, үйл ажиллагааны арга хэрэгсэлд, тэдгээрийн харилцааны зарчмуудад өөрчлөлт хийх шаардлагатай болно.

Энэхүү өгүүлэлд улс төрийн хүрээний өөрчлөлтийг хөндөж байна. Өөрчлөлтийн гол зорилго бол улс төрийн хүрээнд, улмаар нийт нийгэмд аль болохоор өргөн хүрээтэй зөвшилцөл буй болгох явдал юм.

Ийнхүү өргөн хүрээний зөвшилцөл буй болгох хэрэгцээ ардчилсан дэглэм бүхий улс орнуудад буй болсон байна. Энэ нь юуны өмнө ардчиллын загварт хамааралтай юм. Ардчилал бол юуны өмнө ёс зүйн, ёс суртахууны үнэт зүйл юм. Ёс суртахууны үнэт зүйл болохын хувьд ядахдаа ойрын ирээдүйд хувирч өөрчлөгдөхгүй хэмээн үзэж болох юм. Харин энэхүү ёс суртахууны үнэт

зүйлийг бодит амьдралд хэрэгжүүлэх арга хэрэгслийн хувьд өөрчлөгддөг байж болох юм. Орчин үед чухамхүү ийнхүү өөрчлөгдөх нөхцөл бүрдсэн байна. Хэрвээ ардчиллыг ийм арга хэрэгсэл талаас нь тодорхойлбол энэ нь *«улс төрийн үйл явцад оролцох, төрийн эрх баригчдыг шүүмжлэх, тэднийг солих хууль ёсны эрх бүхий иргэдийн оролцсон бүх нийтийн сонгуулиар олонхын санал авч тодорхой хугацаагаар сонгогдсон төлөөлөгчдийн засаглал юм»* (Цанжид А. 2010, 49). Чухамдаа ардчилсан бүхий л орнуудад ийм байж ирсэн гэж болно. Ардчиллын ийм хэлбэр, агуулга нь улс төрийн амьдралыг төрийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн болгон хувиргадаг. Тиймээс ийм ардчиллыг өрсөлдөөний ардчилал хэмээн нэрлэж болох юм. Өрсөлдөөний зайлшгүй гардаг нэг үр дагавар бол популизм байдаг бөгөөд энэ нь сонгогчдод их хэмжээний хүлээлтийг болгодог байна. Гэвч бодит байдалд энэхүү хүлээлтийг бүрэн дүүрэн хангах боломж байдаггүй. Энэ нь улмаар сонгогчдын төр засагт итгэх итгэлийг бууруулдаг нь дэлхий дахинд хийсэн олон судалгаанаас харагдаж байгаа юм. OECD-ийн орнуудад хийсэн судалгаагаар энэ бүлгийн улс орнуудад сонгогчдын төрд итгэх итгэлийн хямрал болж байна гэж дүгнэжээ. 2023 онд эдгээр орны 10 хүн тутмын 4 (39%) нь үндэсний засгийн газартаа өндөр юм уу харьцангуй өндөр итгэлтэй, 44% нь итгэлгүй юм уу итгэл багатай байжээ (Trust in government. OECD survey. 2019). Энэ бол өндөр хөгжилтэй, тиймээс хүн амын амьдралын төвшин сайн, ардчилал хөгжсөн орнуудын тоо баримт юм. Бусад орнуудын үзүүлэлт бүр ч бага байгаа нь ойлгомжтой юм. Хүмүүс (53%) улс орны нь улс

төрийн систем тэдэнд санал бодлоо илэрхийлэх боломж олгохгүй байна хэмээн үзжээ. Энэ бүхэнд үндэслэн судлаачид «Итгэл үргэлжлэн буурсаар байгаа нь нийгмийн эв нэгдэл, улс төрийн оролцоог сүйтгээд зогсохгүй засгийн газруудын үр дүнтэй ажиллах, дотоодын болон дэлхийн хэмжээнд тулгамдаж буй сорилтод хариу үйлдэл үзүүлэх чадварыг хязгаарлаж байна. Олон нийтийн итгэл бол мэтгэлцэн, оролцоог дэмждэг, хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг хөхиүлэн урамшуулдаг, шинэчлэлийг дэмждэг ардчиллын тулгуур багана юм. Засгийн газрууд байгаль орчин, хүн ам зүй, төсөв санхүү, технологийн томоохон сорилтуудын нөхцөлд итгэлцлийг бэхжүүлэх, үр дүнтэй засаглах, ардчиллын уян хатан байдлыг хангах талаар хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай байна» (Trust in government. OECD survey. 2019). Иргэдийн төр засагт итгэх итгэл нь тэдний хүлээлтийг хангах төр засгийн байгууллагуудын чадвар, үйл ажиллагааны үр нөлөөнөөс гадна, улс төрийн оролцооны боломж, төрийн байгууллагуудын ил тод байдал зэргээс ихээхэн хамааралтай юм. Ил тод байдлыг хязгаарладаг зүйл бол авлига, алдаа дутагдлыг нуух эрмэлзэл зэргээс гадна улс төрийн өрсөлдөөн юм. Өнөөгийн нөхцөлд улс төрийн нэг юм уу цөөн нам парламентын олонхыг бүрдүүлж, засгийн газарт суудал эзлэх тохиолдолд төрийн эрх мэдлийг хуваах, харилцан тэнцвэртэй байх зарчмыг тодорхой хэмжээгээр гажуудуулдаг. Энэ нь ялангуяа Вестминстерийн гэж нэрлэгддэг загварт улам тод илэрдэг байна. Энтони Грейлинг энэхүү загвар нь том хэмжээтэй эзэнт гүрнийг удирдах хэрэгцээнээс үүсэлтэй ба өдгөө Их

Британи, Австрали, Канад, Шинэ Зеланд улсууд болон нийтдээ дэлхийн тавь гаруй оронд байдаг бөгөөд үүссэн газрынхаа хувьд ч, үүнээс үүдсэн төрийн дэг журмын хувьд ч тохиромжгүй юм уу аюултай болсон хэмээн дүгнэсэн байна. Уг загварыг бага зэрэг өөрчилж Ерөнхийлөгчийн засаглалтай болсон АНУ -д ч энэ загварын сул тал ажиглагдах болсон хэмээн шүүмжилсэн байна (Grayling A.C. 2021, 2). Тэр бээр уг загварын сул тал нь институцийн хүрээнд болон загварын үйл ажиллагааны практик, нам, улс төрчдийн үйл ажиллагаанд илэрч байгаа гэж үзэж байна. Институцийн хүрээнд бол дээр дурдсан төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг хөсөрдүүлэх явдлаар илэрч байгаа аж. Харин практик үйл ажиллагааны хувьд хэт намчирхсан бодлого, үйл ажиллагаа, шүүх, гүйцэтгэх засаглалын зүгээс гардаг үндсэн хуулийн бус үйлдэл, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалаас гадуур явагддаг элдэв явуулга, хэвлэл, мэдээллийн үйл ажиллагааны зохисгүй байдал зэрэг нь ардчилалд сөрөг нөлөөлж байна гэж үзсэн байна.

Ардчилсан системүүдэд төр, улс төрийн байгууллагуудын ил тод бус байдал, ардчилсан, үр нөлөөтэй хараат бус хяналт хангалтгүй байгаа нь төрийн нэр хүндийг унагах хүчин зүйлийн нэг болж байна. Европын орнууд ихэвчлэн хувь тэнцүүлэх төлөөлөлтэй байдаг. Гэвч эдгээр орнуудад ч төрийн эрхийг барьж ирсэн төвийн намуудын байр суурь суларч байна. Кшиштоф Бвендовскийн тооцоолсноор өдгөө Европын орнуудад хэт барууны намууд сонгогчдын тавны нэгээс гуравны нэгийг хүртэлх хувийг дагуулж байгаа ажээ (Carnegieendowment.org 2024).

Европын орнуудад ийнхүү

төрийн эрхийг ээлжлэн барьж ирсэн зүүн, баруун төвийн намуудын байр суурь суларч, хэт туйлширсан намууд, ялангуяа барууны намуудын нөлөө ихсэж байгаа нь дэлхийн геободлогын өөрчлөлт, даяаршил, цагаачлал, нийгмийн дотоодод гарч байгаа өөрчлөлтүүдтэй холбоотой байна. Эдгээр оронд хүн амын нэлээд хэсэг нь улс төрөөс гадуур хаягдсан, улс төрд оролцож үгээ хэлэх, нөлөөлөх боломжгүй байна хэмээн үзэх болжээ. Ажилчин анги өмнөх үеийнх шиг нийгмийн гадуурхагдсан тусдаа анги байхаа нэгэнт больж, өөрсдийгөө төрийн албан хаагчид, жижиг үйлдвэрлэгчидтэй нэгэн төвшинд тавих болсон ба тэдэнтэй ижилхэн аж төрөх хэв маягтай болсноос гадна боловсролтой болж, бусдын адил мэдээлэл авах болсон байна. Үйлчилгээний салбар эдийн засагт томоохон байр эзлэх болж, тэнд ажиллагсад ч ажилчдын нэгэн адил нөхцөл байдалд аж төрөх болжээ. Товчхондоо нийгэмд дунд давхаргын эзлэх байр суурь, хэмжээ ихсэж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд дуу хоолойгоо нэмэрлэхийг хүсэх болсон аж. Түүний нөгөөтээгүүр нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд болж, ирээдүй тодорхойгүй байгаа, нийгмийн институцүүд түүнд зохицож өөрчлөгдөхгүй байгаа, хуучин бүтэц шинэ нөхцөлд үр нөлөө багатай байгаа нь нөлөөлж байгаа ажээ. Нийгмийн томоохон бүлгүүд хооронд ч зөрчил үүссэн аж. Насжилт ихсэж, нийгмийн халамж хүндэрсэн, нэгэнт ажил, цалинтай болж, амьдрал нь зохих төвшинд хүрсэн болон хөдөлмөрийн зах зээлд шинээр орж, ажил олох, сайн цалинтай болох боломж багатай байгаа бүлгүүд хооронд ялгарал гарч байгаа

бололтой (Is democracy in crisis?. 2007).

Үүний зэрэгцээ эрх баригчид тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар дорвитой алхам хийхгүй, байр суурь нь тодорхой бус, дагалдагчдынхаа сонирхлыг харгалзах маягтай байгаа боловч, үүрэг хүлээдэггүй, олон нийтийн санаа бодлыг дагалдах маягтай байгаа нь дургүйцлийг улам бүр нэмэгдүүлдэг ажээ. Нийгэмд ангиудын ялгаа төдий л хүчтэй бус болж, намууд сонгуульд ялахын тулд аль болохоор нийгмийн бүхий л бүлгүүдээс санал авахыг эрмэлздэг болсон нь бодлогоо ил тод хэлэхээс болгоомжлон бүрхэг томьёололтой “дам хэл” ашиглахад хүргэсэн ажээ. Намууд тодорхой бодлогыг дэмжих талаар бус, харин бусад намуудынхаа эсрэг санал өгөхийг л уриалах болсон аж. «Сонгогчид уламжлалт намууд өөрсдөөс нь урвасан мэт сэтгэгдэлтэй болж, улмаар популистуудыг жинхэнэ эсэргүүцлийг нь илэрхийлэгч хэмээн үзэж тэдэнд итгэх хандлагатай болов» (Cesare Pinelli. 2024).

Энэ бүхнээс дүгнэлт хийх гэж оролдох юм бол Европ дахинаа иргэд улс төрийн оролцоог өргөжүүлэхийг шаардаж байгаа бөгөөд нийгмийн хэмжээний шинэ зөвшилцөл хэрэгтэй байгаа ажээ. Хоёрт, өрсөлдөөнд суурилсан намуудын бодлого, үйл ажиллагааг өөрчлөх, шинэ нөхцөлд нийцсэн шинэ маягийн намууд буй болох шаардлага гарч байгаа шиг байна. Гуравт, иргэд эрх баригчид, улс төрийн намуудад итгэх нь буурч байгаагаас илүү түргэн үр дүнд хүрэх, илүү шууд оролцооны хэлбэрүүдийг ашиглах болсон аж (Selen A. Ergen., Jean Paul Gagnon. 2014, 1-10).

Судлаачид нөхцөл байдлыг янз бүрээр үнэлж байна. Зарим нь ардчиллын хямрал болж байна гэж

үзэж байхад нөгөө зарим нь шинэ нөхцөл байдалтай уялдан ардчилал хувиран өөрчлөгдөж байна гэж үзэж байна. Вольфганг Меркел ардчиллын хямралын талаарх яриа хэлэлцүүлгийн байдлыг дүгнэн гурван чиглэл болгон хуваажээ. Нэгд, улс төрийн элит, улс төрийн намууд, парламентууд, засгийн газруудад итгэх итгэлийн хямрал болж байна гээд энэ бүхнийг нэгтгэн “ардчиллын хямрал” хэмээн нэрлэх нь давамгайлж байна. Хоёрт, улс төрийн онол анхнаасаа л ардчилал бол хямралгүйгээр боломжгүй гэж үзэж Платон, Аристотель, Полибий нарын зэрэг эрт үеийн болон Алесис де Токвиль, Карл Маркс, Макс Вебер нарын зохиол бүтээлийг дурдаж байна. Гуравт, ардчилал хямралд орсон гэдгийг үгүйсгэж байгаа юм уу эргэлзэх байр суурь. Ардчиллын хямралын тухай үзэл нэн эртнээс эхтэй бөгөөд тасралтгүй үргэлжилсээр одоог хүрч байгаа аж. Сүүлийн үеийн төлөөлөгчдөөс дурдвал Чантал Моуффе, Колин Оруч болон бусад олон судлаачдыг нэрлэж болох ба бүр “post-democracy” гэдэг сэдэвтэй хэлэлцүүлэг хүртэл явагдсан байна. (Wolfgang Merkel. 2014, 11-25).

Ардчилал шинэ нөхцөл байдалд нийцэхийн тулд өөрчлөгдөж байгаа гэх болон ардчилал хямарч байна гэх нь нэг л үзэгдлийн хоёр өөр нэр юм. Хамжих засаглал, зөвлөлдөх ардчилал, оролцоот төсөв гэх мэтийн шинэ хэлбэрүүдийг илүү их онцолж байгаа судлаачид ардчиллын өөрчлөлт, хөгжлийн тухай ярьдаг бол сонгогчдын итгэлийн бууралт, популизмын дэмжлэгийн өсөлт зэргийг онцолбол хямралын тухай ярьж байгаа гэвэл дэгс болохгүй юм. Өрсөлдөөнийг туйлшруулдаг улс төрийн уламжлалт намуудын үйл ажиллагааны арга

хэлбэр, улс төрчдийн сэтгэлгээ өөрчлөлтөөс хоцорч байгаа нь ил болж байх шиг байна.

Нийгмийн улс төрийн амьдралд гарч байгаа өөрчлөлт ардчилсан гэж үзэгддэг орнуудын хувьд нийтлэг шинжтэй болж байна. Энэ нь улс төр-нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшнөөс төдийлөн хамаарахгүй шахам болжээ. Учир нь хөгжингүй орнуудаас дорой хөгжилтэй байгаа орнуудад хэдийгээр дундаж давхарга бага хувийг эзэлдэг боловч хүмүүсийн боловсролын төвшин, мэдээллийн хүртээмж, нээлттэй байдал, бусад оронд очиж “нүд тайлах” боломж ихэссэн, хүн амын орлогын ялгаа их байгаа зэрэг нь улс төрөөс “хүнийсэх”, улмаар эсэргүүцлийг сонгуульд үл оролцох байдлаар дуугүй, эсвэл элдэв жагсаал цуглаан, хууль бус үйл ажиллагаагаар идэвхтэй илэрхийлдэг болж байна. Нөгөө талаар эдгээр орны улс төрийн амьдрал бүхэлдээ одоо хуучирч буй гээд байгаа өрнөдийн орнуудын загварыг хуулбарлах маягтай байгаа нь нөлөөлж байна. Хүмүүсийн амьдралын хэв маяг ч зарим талаар, ялангуяа хот суурин газруудад “хуулбар” маягтай болж байна. Түүнчлэн эсэргүүцэл хөдөлгөөн гарахад улс төрийн сонирхлын үүднээс хийж буй эрх чөлөөний тухай гадаад, дотоодын сурталчилгаа зохих нөлөө үзүүлж байгаа юм.

Кембрижийн их сургуулийн профессор Дэвид Ранчимен орчин үеийн ардчилал юу болон хувирч байгаа талаар бичихдээ “Ихэнх ардчилсан нийгэмд ард түмэн ямар ч үед ажиглагч байдаг. Тэд өөрсдийнхөө нэрийн өмнөөс сонгогдсон төлөөлөгчид нь улс төрийн шийдвэр хэрхэн гаргаж, сонгуулийн үеэр тэднээс дэмжлэг авах гэж оролдохыг нь л харж байдаг. Хэрэв

ардчилал ийм болсон бол ардчиллыг сүйтгэх гэсэн оролдлогыг маш сайн халхавчлах болно, учир нь энэ хоёр гайхалтай төстэй харагдаж байна.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан энэ байдлыг тодорхойлохын тулд “заалны ардчилал”, “үзэгчдийн ардчилал”, “плебисцитийн ардчилал” гэсэн нэр томъёо гаргаж ирсэн. Эдгээр нэр томъёо нь хэтэрхий зөөлөн байж магадгүй: “зомби ардчилал” гэвэл илүү дээр байж магадгүй юм” гэжээ. (Runchimen D. 2019, 47). Профессорын дүгнэлт хатуудсан байж мэдэх боловч асуудлын голыг оносон байна. Улс төрийн хүрээ, олон улсын зарим байгууллагад ажилладаг юм уу тэдгээрт ойр байдаг профессорууд ардчиллыг гол төлөв магтан дуулдаг бол академик чиглэлийн судлаачид илүү бодитой судалгаа хийж, дүгнэлт гаргадаг. Эхний хүмүүсийн амыг дагавал “өвчин хэтэрхий хүндэрч” засал авахад хэцүү болно. Харин гэмтэл согогийг эртхэн ажиглаж, засах юм бол энэ нь аливаа зүйлийн өөрчлөлт хөгжлийн хэвийн үйл явц юм. Энэ талаар Ч. Дэмчигдоржийн бичсэнийг сануулахад илүүдэхгүй биз ээ. «Аливаа бодос туйлд хүрвээс эрхгүй мошно. Мохвоос эрхгүй хувьсана. Хувьсваас эрхгүй нэвтэрнэ. Аливаа их бага үйлсийг ялгахгүй жил удахад яван явсаар гэм сэв орж хувьссаар уг дүрмээс өшүүд өөр болоход хүрнэ. Үүний дээр бас цаг улирлын хувьсал адилгүй тул энэ хоёр зүйл хавсарваас эрхгүй буурч доройтно. Энэ ч бас өөрөө тохирох ёс буюу. ... Ер аливаа юм удваас хуучирч эвдрэхэд хүрэх нь байдалд өөр болох нь буюу, үүнийг цаг цагт сэлбэн засваас шинэ болж үл эвдрэх нь мөнхүү өөрөө болсон ёс мөн болой» (Дэмчигдорж Ч. 2002, 96).

Энэ бүхнээс үүдэн “өрсөлдөөний

ардчиллыг” хэрхэн “зөвшилцлийн ардчилал” болгон хувиргах вэ гэдэг асуудал дэвшигдэж байгаа юм. Өрсөлдөөнийг үгүй хийж болохгүй нь ойлгомжтой. Төрийн эрхийн төлөөх өрсөлдөөн бол ардчиллын амин сүнс хэмээн үзэж болох юм. Гэвч өрсөлдөөн ёс суртахууны хэм хэмжээ, улс орны болон хувь хүний ашиг сонирхлыг үл хайхран зөвхөн өрсөлдөгчдийгөө ялах, хүч хэрэглэхээс өөр бусад ямар ч хамаагүй аргаар эрх мэдэлд хүрэх хэрэгсэл байж болохгүй юм. Дэлхий дахины улс төрийн амьдралд санал худалдан авах, санал тооллогыг будилаантуулах, сонгогчдыг дарамтлах, худал амлаж, хууран мэхлэх, өрсөлдөгчдөө ор үндэсгүй гүтгэх гэх мэт болон сонгуулийн үед гардаг сөрөг үзэгдлүүдээс эхлэн улс орны эрх ашигт нийцэх эсэхээс үл хамааран эрх баригчдын бодлого, үйл ажиллагааг бүрэн жадлан эсэргүүцэх, эрх баригчдын зүгээс бусдын гаргаж байгаа үр ашигтай саналыг үл тоомсорлох, үйл ажиллагаа нь ил тод бус байх, дутагдал доголдлыг нуун дарагдуулах, элдэв явуулга хийх, илт хууль зөрчих, шүүх засаглалд нөлөөлөхийг оролдох зэрэг маш олон гажуудал гардаг нь хүн бүрийн мэдэх зүйл болсон юм. Энэ бүхэн өрсөлдөөний утга учрыг алдагдуулж, улмаар ардчиллыг хямрахад хүргэж байгааг дээр дурдсан шинжилгээ харуулж байгаа юм. Платон “Засаглалын хэлбэр бүр үндсэн зарчим нь хэтэрснээс мөхөх хандлагатай байдаг” гэсэн байдаг (Durant W. 2006, 26). Платон өөрөө тэр үеийнхээ ардчиллын мөхөх боломжийг ядуусын бослоготой холбож байсан ч түүний хэлсэн энэ мэргэн үгийг өнөө үед хамааруулбал чухамхүү улс төрийн утга учиргүй тэмцэл, өрсөлдөөнтэй

холбож болох юм. Үүнийг Ж.Тойнби бас ажигласан шиг байдаг. Тэр бээр «орчин үеийн өрнөдийн ардчиллын чин эрмэлзэл нь улс төрийн практикийг христ ёсны бүх нийтийн ах дүүсэг сэтгэлээр баяжуулах явдал боловч бодит байдалд улс төр нь дайнч, бөгөөд хэсэг бүлгийн тэмцэл тулаанаар дүүрэн болжээ» (J.Toynbee 2001, 23).

Энэ бүхнийг улс төрийн өрсөлдөөнийг үгүй хийх ёстой гэдэг бодлын үүднээс бус, түүнийг илүү эрүүл болгох, өрсөлдөгчид улсын хөгжил дэвшил, сонгогчдын сайн сайхны төлөө гэсэн үндсэн зарчимд захирагддаг болгоход чиглүүлэх, улс төрөөс “хүнийссэн” хүмүүсийн дуу хоолойг сонсдог байхын тулд засаж сайжруулах үүднээс ярьж байгаа хэрэг юм. Тэгэхээр ардчиллыг засах, сайжруулах арга хэрэгслийг гаднаас бус, дотроос нь эрэх хэрэгтэй болж байгаа юм. Ингэх нь манай улсад хөгжил дэвшлийн төлөө, “гүйцэх” юм уу “угтах” хөгжлийн төлөө дээр дурдсан бүх нийтийн зөвшилцлийг

буй болгох гэсэн санаатай нийцнэ хэмээн үзэж байгаа юм.

Тэр тусмаа дэлхийн ардчилсан бусад оронд гарч байгаа хямралын дохио гэмээр дээр дурдсан үзэгдлүүд манай улс төрд ч нэгэнт буй болсныг харгалзах хэрэгтэй биз ээ. Баримт түшье.

“Цогц хөгжлийн үндэсний төв”-өөс “Сонгогчийн зан, төлөвийн судалгаа”-г хийсэн байна. Сонгогчийн зан төлөвийн судалгаагаар сонгогчдын улс төрийн болон сонгуулийн боловсрол ямар байна вэ, түүндээ үндэслэн хэр зэрэг рационал сонголт хийх чадамжтай байгааг тодорхойлж болно. Тус байгууллага 2020 оны сонгуульд саналаа өгсөн, 18-аас дээш насны, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд аймаг болон нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нийт 1000 иргэнийг түүвэр байдлаар сонгон анкет асуулгын арга болон фокус бүлгийн ярилцлагын аргаар судалгааг хийжээ. Түүний нэг асуулгын хариуг дараах зурагт үзүүлжээ.

Зураг 2. Төрийн бодлогод нөлөөлөх боломж (Цогц хөгжлийн үндэсний төв. 2020)



Эндээс үзвэл сонгогчдын нэлээд хэсэг нь улс төрөөс “хүнийсэх” хөрс нэгэнт буй болжээ. Тэгэхээр улсын сайн сайхан ирээдүйн төлөө бүх

нийтийн зөвшилцөл буй болгох нь бэрхшээлтэй болж эхэлж байна гэсэн үг. О.Хатанболд нарын судалгаагаар судалгаанд оролцогчдын 40.5% нь

ардчилал манай оронд сайн хөгжиж байна гэж үзсэн байна (Хатанболд О. 2016, 191-205). Түүнчлэн У.Батцэрэн, Т.Хулан нарын судалгаагаар судалгаанд оролцогчид бодлого боловсруулах, шийдвэр гаргах төвшинд дэх оролцоогоо хангалтгүй гэж үнэлсэн байна. Тэдний 37.5% нь оролцоо огт хангалтгүй, 60% нь төдийлөн хангалуун бус гэж хариулсан ажээ (Батцэрэн У., Хулан Т. 2016). Хэрхэн яаж, эл үржил шим муутай болж байгаа хөрсийг багасгах юм уу арилгах вэ?

Үүнийг юуны өмнө Улсын их Хуралд нийгмийн янз бүрийн бүлгийн сонирхлын төлөөллийг буй болгох замаар хэрэгжүүлж болох юм. Гол арга зам бол юуны өмнө Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлэх зарчмаар явуулах юм. Манай орон одоог хүртэл мажоритар системийн хувилбаруудыг болон сүүлчийн сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсан билээ. Мажоритар болон хувь тэнцүүлэх систем аль аль нь давуу болон сул талтай. Аль тал нь давамгайлах нь тухайн үеийн нөхцөл байдлаас хамааралтай юм. Тиймээс аль нэг нь ямар ч үед давуу талтай гэж үзэх нь буруу. Ардчилсан сонгууль явуулж эхэлсэн эхний үед манай сонгогчид үндсэндээ хуучин болон шинэ улс төрийн хүчнийг дэмжсэн маягтай хоёр хандлагатай байсан. Нөгөө талаар мажоритар системийн давуу тал давамгайлах боломж агуулагдаж байсан билээ. Ардчилал болон зах зээлийн харилцаанд шилжихийг эсэргүүцдэг улс төрийн хүчин байсангүй. Иргэдийн хувьд ч дийлэнх нь улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хийж, аж байдлаа дээшлүүлэх эрмэлзэлтэй байсан юм. Ийм нөхцөлд улс төрийн аль хүчин эдгээр зорилтыг

амжилттай хэрэгжүүлж чадах вэ гэдэг нь сонголт хийх гол шалгуур болж байлаа. Төрийн эрхэнд гарсан улс төрийн хүчин сайн ажиллавал иргэд нийтээрээ хожих ба сонирхол нь хохирох бүлэг юм уу бүлгүүд байхгүй хэмээн үзэж байсан хэрэг юм. Онол номлолын хувьд ч ийм байр суурийг дэмжих судалгаанууд байсан нь тэр үед тухайлбал, эл өгүүллийг тэрлэгч миний байр суурьд нөлөөлж байсан ба надтай ижилдүү байр суурьтай хүмүүс ч бас байсан юм. Гаднын судлаачдын дотроос эл асуудлыг сайтар судалсан хүн бол Лийпхарт юм. Тэр бээр Европын улс орнуудын улс төрийн тогтолцоог судлан ардчиллын хоёр үндсэн загвар байна хэмээн үзсэн байдаг. Үүнд олонхын буюу мажоритар болон хувь тэнцүүлсэн сонгуулийн системтэй загварууд байна гээд нэг үндэстнээс бүрдсэн хүн амтай, соёлын хувьд ялгаралгүй улс орнуудад эхнийх нь илүү зохимжтой байна гэсэн санааг хэлсэн байлаа. Гэвч нөхцөл байдал хувирч өөрчлөгддөгийг харгалзах ёстой.

Мажоритар систем нь хоёр намын систем буй болгох хандлагатай байдаг. Үүнээс үүдэн мажоритар системийг удаан хугацаанд хэрэглэх нь сонгогчдыг хоёр хувааж талцуулах нөлөөтэй байдаг нь ийм системтэй улс орнуудын байдлаас харагдаж байна. Ийм хандлага хүчтэй илэрч байгаа орон бол АНУ юм. Манай орны хувьд ч сонгогчдын улс төрийн идэвхтэй хэсэг нь МАН болон АН-ын хооронд хуваагдах хандлагатай байж ирлээ. Тэдгээрийн цаана сонгуульд оролцдоггүй хэсэг болон жижиг намуудыг дэмждэг сонгогчид үлдэж байгаа юм. Үүнийг сүүлчийн сонгуулиудын дүнгээс харж болно.

Хүснэгт 1. УИХ-ын сонгуулийн дүн

	2012	2016	2020
Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүний тоо, мян	1, 841.81	1,911	2,004
Санал өгсөн хүний тоо, мян.	1,238.5	1,420.8	1,475.8
Оролцооны хувь	67.3 (67,28)	74.3 (73,58)	73.6 73,6)
Санал өгөөгүй хүний хувь	32.7	25.7	26.4

Эх сурвалж: Статистикийн хороо (Сонгуулийн ерөнхий хороо)

2016 болон 2020 оны сонгуулийн ирц 2012 оныхтой харьцуулахад өссөн боловч сонгогчдын 26 орчим хувь нь сонгуульд санал өгөөгүй байна. 1992 оны сонгуулийн ирц 96,

1996 оны сонгуулийн ирц 92 хувь байсантай харьцуулахад хорь орчим хувиар буурчээ. 2024 оны УИХ -ын сонгуулийн ирц 2020 оныхоос буурч 69.3 хувьтай байв.

Хүснэгт 2. УИХ-ын эхний 4 сонгууль болон сүүлийн 4 сонгуульд улс төрийн намуудын авсан саналыг харьцуулсан нь

Улс төрийн нам	Авсан саналын дундаж хувь (1992-2004)	Авсан саналын дундаж хувь (2008-2020)
МАХН/МАН	49.33	41.9
АН	36.43	34.1
Бусад нам	14.25	24

Эх сурвалж: Монгол Улсын сонгууль (1992-2021)

Эл хүснэгтээс харахад сонгогчдын 76 орчим хувь нь МАН болон АН-д хуваагдаж саналаа өгсөн ба харин бусад намд санал өгөгчдийн хувь аажмаар нэмэгдэж байна. Гэвч бусад намаас УИХ-д суудал авахгүй шахам

байсан юм. УИХ-ын гишүүнээр сонгогдсон болон сонгогдоогүй нэр дэвшигчдийн авсан саналын харьцаа бас өөрчлөгдөж байгааг судалгаа харуулж байна.

Хүснэгт 3. УИХ-д сонгогдсон болон сонгогдоогүй нэр дэвшигчдийн авсан саналын өөрчлөлт

Сонгууль	Сонгогдсон нэр дэвшигчдийн авсан саналын хувь	Сонгогдоогүй нэр дэвшигчдийн авсан саналын хувь
1992	58.2	41.7
1996	53.0	46.0
2000	52.2	47.7
2004	54.0	45.0
2008	50.4	49.5
2012	41	58
2016	46	53
2020	45.9	54.0

Эх сурвалж: Монгол Улсын сонгууль (1992 – 2021) (The Asia Foundation 2023)

УИХ-ын гишүүнээр сонгогдсон болон сонгогдоогүй нэр дэвшигчдийн авсан санал 2008 онд үндсэндээ

тэнцэж ирснээ түүнээс хойш сонгогдоогүй нэр дэвшигчдийн авсан саналын хувь илүү гарч эхэлжээ.

Ийм өөрчлөлт нь мажоритар (болон холимог) тогтолцооны сул тал хүчтэй болж байгааг харуулж байгаа бөгөөд сонгуулийн системд үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсныг харуулж байгаа юм. Эсрэг тохиолдолд УИХ-д ч, нийт нийгмийн хэмжээнд ч хөгжлийн үйл явцад эерэг нөлөө үзүүлэхүйц зөвшилцөл буй болох бололцоогүй юм. Нөгөө талаас ийм байдал нь төлөөллийн ардчиллын зарчмын эсрэг агуулгатай болж байна. Учир нь Монгол Улс бол төлөөллийн ардчилалтай орон юм. Төлөөллийн ардчилал нь хууль тогтоох байгууллагад иргэдийн олонхын сонирхол төлөөлөлтэй байх учиртай. Хэрвээ УИХ-д сонгогдсон нэр

дэвшигчдийн авсан саналын хувийг нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын тоонд харьцуулбал дээрх хүснэгтэд байгаа тоо бүр ч бага болох нь тодорхой юм. Ийм нөхцөлд хууль тогтоох байгууллагад төлөөлөлгүй байна гэж өөрсдийгөө тооцож байгаа сонгогчид гудамж талбайд жагсах болон шууд оролцооны бусад аргаар санаа бодлоо илэрхийлэх, төр засгийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх болно хэмээн үзэж болно. Эдийн засаг, нийгмийн нөхцөлийн өөрчлөлт, эрх барьж буй хүчний үйл ажиллагааны үр дүнгээс хамааран сонгогчдын байр суурь их хөдөлгөөнтэй байдаг байна.

Зураг 3. Сонгогчдын улс төрийн байр суурийн өөрчлөлт (Цогц хөгжлийн үндэсний төв, 2020)



Эндээс үзвэл сонгогчдын боловсрол өсөх тусам улс төрд шүүмжлэлтэй хандах нь нэмэгдэж байна. Ийм үзэгдэл Европ дахинаа 1970 -аад оноос нэмэгдэж эхэлсэн байдаг. Дээд боловсролтны 34.1 хувь нь аль ч намыг дэмждэггүй ба 8.3 хувь нь дэмждэг намайг өөрчилсөн ажээ. Нийлээд 42.3 хувь болж байна. Энэ бол боловсролтой хүмүүсийн нэлээд хэсэг нь “УИХ -д миний эрх ашгийг илэрхийлдэг улс төрийн хүчин байхгүй” гэсэн мэдрэмжтэй байна

гэсэн үг.

Нийгмийн сүлжээгээр илэрхийлэгдэж байгаа иргэдийн санаа бодол, илэрхийлж байгаа арга, өнгө аясыг харвал талцах байдал улам нэмэгдэж, зарим тохиолдолд экстремист маягийн санаа бодол ч цухалзах болсон байна. Сонгогчдын үзэл бодол, сонирхол 90 –ээд оныхтой харьцуулбал олон янз байдалтай болжээ хэмээн дүгнэж болно.

Энэ бүхнээс үзвэл хөгжлийн төлөө өргөн хүрээний зөвшилцөл буй

болгох бодит шаардлага үүссэн байна. Иймээс сонгуулийн тогтолцоог цэвэр хувь тэнцүүлэх зарчимд нийцүүлэх шаардлагатай байна. Ингэх нь Монголын ардчиллын загварыг төлөөллийн ардчиллын үзэл санаад ч нийцүүлэх болно. Сонгуулийг дүнг хувь тэнцүүлэх аргаар гаргаснаас өрсөлдөөн бүр алга болохгүй боловч мажоритар аргатай харьцуулахад талцал, хуваагдал нь хоёр нам зонхилж буй үеийнхээс зөөлөн байх магадлалтай юм. Нөгөө талаар аль нэг нам 50

хувиас дээш санал авах тохиолдол ховор байдаг учраас тогтолцооны үйлчлэл нь намуудыг зөвшилцөл хийхээс өөр аргагүй байдалд оруулдаг. Энэ нь намууд хоорондын харилцааг ч зөөлөн, бүтээлч байдалтай болгодог. 2024 оны УИХ -ын сонгуулиар намуудын жагсаалтад өгсөн саналын хуваарилалтыг хэрвээ хувь тэнцүүлэх тогтолцоог хэрэглэвэл гарах дүн ямар байх вэ гэдгийг барагцаалан харуулах зүйл гэж үзэж болох юм.

Хүснэгт 4. УИХ сонгууль 2024 (намуудын жагсаалтаар авсан санал)

Намын нэр	Авсан саналын тоо/хувь
Монгол ардын нам	509,482/35.01
Ардчилсан нам	438,506/30.13
ХҮН нам	151,111/10.38
Үндэсний эвсэл	75,196/5.17
Иргэний зориг ногоон нам	73,006/5.02
Шинэ нэгдсэн эвсэл	69,682/4.79
Үнэн ба зөв нам	40,783/2.80
Иргэний хөдөлгөөний нам	20,443/1.40
Бүгд найрамдах нам	19,635/1.35
Иргэдийн оролцооны нэгдэл нам	13,733/0.94
Ард түмний хүч нам	10,614/0.73
Сайн ардчилсан иргэдийн нам	6,104/0.42
Эх орон нам	5,621/0.39
Эрх чөлөөний эвсэл нам	4,738/0.33
Ард түмний олонхийн засаглал нам	3,619/0.25
Монголын хүний төлөө нам	3,461/0.24
Монголын либерал Ардчилсан нам	2,820/0.19
Эх орончдын нэгдсэн нам	2,168/0.15
Монголын Социал демократ нам	1,531/0.11
Монголын консерватив нам	1,485/0.10
Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1,450/0.10

Эх сурвалж: <https://ikon.mn/elections/2024>

Эндээс үзвэл босгыг 5 хувиар тогтоож, хувь тэнцүүлэн суудал хуваарилбал УИХ -д 5-6 нам хууль ёсоор орох боломжтой байна. Тэд санал өгсөн сонгогчдын 90.5 хувийг төлөөлөх тооцоо гарч байна. Энэ бол сонгогчдын төлөөллийг хангах талаасаа маш сайн үзүүлэлт юм. Ер нь сонгуулийн дүн бол сонгогчид тухайн намд тавьж байгаа дүн учраас намууд үнэлгээгээ мэдэх, улмаар санал их аваагүй хүчнүүд “тайвшран”, бусадтай нэгдэж нийлэх, эсвэл улс төрөөс хөндийрөх үйл явц буй болдгийг дэлхийн улс төрийн амьдрал харуулж байгаа юм. 2024 оны УИХ-ын сонгуулийн дараа УИХ -д 5 нам суудалтай болж, хамтарсан засгийн газар байгуулагдсан нь цаашдаа бүрэн эрхийн хугацаа дуустал тогтвортой ажиллаж чадах эсэх нь монголчуудын зөвшилцөх чадвар, намууд, улс төрийн лидерүүдийн төлөвшлийн сорилт болох болно.

Хувь тэнцүүлэх тогтолцооны сөрөг тал бол парламентад олон нам орох, үүнээс үүдэн засгийн газрыг байгуулж чадахгүй байх, засгийн газар тогтворгүй болох зэрэг юм. Хэрвээ улс төрийн намууд улс орны хөгжлийн эрх ашгийн үүднээс үнэхээр өргөн хүрээний зөвшилцөл хийх улс төрийн хүсэл зоригтой байгаа бол эл сөрөг талыг зөөлрүүлж болох юм. Нөгөө талаас хуулийн зохицуулалтаар уг асуудлыг бас шийдвэрлэж болох талтай. Эвслийн засгийн газар байгуулахад маргааны гол асуудал бол аль нам засгийн газрын хэдэн гишүүнтэй байх болон ямар яамыг авах вэ гэдэг асуудал байдаг. Үүнийг парламентад авсан суудлын тооноос нь хамааруулан урьдчилан хуваарилж хуулиар баталгаажуулж болох юм. Ийм тохиолдолд төрийн бодлого хүн амын

өргөн хүрээний сонирхлыг тусгах ба засгийн газар намын бус ард түмний засгийн газар болох боломж ямар нэг хэмжээгээр буй болно. Түүнчлэн Засгийн газрын тогтвортой байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хийж болно. Ийм нөхцөл боломжийг бүрдүүлэхэд улс төрийн намуудын төлөвшил, лидерүүдийн байр суурь, үндэсний хэмжээний удирдагч болж өсөж чадсан эсэх нь онцгой нөлөөтэй юм. Тэгэхдээ энэ бол ямар ч тохиолдолд засгийн газар огцордоггүй байна гэсэн үг биш юм. Өргөн хүрээний зөвшилцөл буй болгохын тулд парламентад сонгогчдын хэсэг бүлгийн төлөөллийг аль болохоор өргөн оруулах шаардлагатай. Үүний тулд иргэд сонгуульд заавал санал өгдөг байхаар хуульчилж болно. Төр засгаа эмхлэн байгуулахад оролцох нь эх орноо хамгаалж, цэргийн алба хаахтай эн тэнцүү чухал асуудал юм. Ялгаа нь гэвэл сонгуульд хүйс харгалзахгүй заавал бүгдээрээ оролцдог байх явдал юм. Дэлхий дахинд иргэд албан журмаар сонгуульд оролцож, санал өгдөг байх зохицуулалттай улс орнууд бий.

АНУ-ын зарим муж улсууд, Австрийн зарим муж, Францын сенатын сонгууль зэрэгт заавал санал өгөх шаардлагыг хуульчилсан байсан боловч сүүлийн үед хүчингүй болгосон байдаг. Энэ нь нэгд, иргэдийн боловсрол, улс төрийн боловсрол дээшилсэнтэй холбоотой гэж үзсэнийх юм. Нөгөө талаар сонгуулийг хөнгөвчлөх зорилго агуулж байсан байж болох юм. Өнөөдөр Грек, Австрали, Болгар, Швейцар, зэрэг олон оронд сонгуульд заавал саналаа өгөх журамтай ажээ. Латин Америкийн нэлээд оронд ийм журамтай байсан ба одоо ч зарим улс ийм зохицуулалттай

байна. Тэгэхдээ далаас дээш насны хүмүүс, тухайн өдөр эх орондоо байгаагүй хүмүүс сонгуульд сайн дураараа оролцдог байх зэрэг янз бүрийн зохицуулалттай. Аргентин улсад зөвхөн 16-18 насныхан сонгуульд заавал оролцож саналаа өгөх үүрэгтэй байдаг байна. Сонгуульд оролцохыг шаарддаг орнуудын зарим нь иргэн сонгуульд оролцоогүй тохиолдолд зохих шийтгэл оноодог байхад заримд нь тийм журам байхгүй. Уг асуудалд хамгийн хатуу ханддаг улсуудын жишээнд Грек, Сингапур зэрэг улсуудыг оруулж болох юм. Грек улс 2000 оныг хүртэл 70 -аас доош насны сонгуульд оролцоогүй иргэнд паспорт, жолооны үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх олгохгүй байх, зэрэг хатуу арга хэмжээ авч байсан бол Сингапурт сонгуульд оролцоогүй иргэнийг өөрөө өргөдөл гарган сонгуульд оролцоогүй шалтгаанаа тайлбарлах хүртэл нэрийг нь сонгогчдын нэрсийн жагсаалтаас хасаж, хэрвээ хүндэтгэх шалтгаангүй гэж үзвэл тодорхой хэмжээний төлбөр төлүүлж, дараагийн сонгуулиудаар нэрээ дэвшүүлэх эрхийг нь хасдаг байна. Ерөнхийдөө сонгуульд заавал оролцохыг шаардах нь тухайн орны иргэдийн онцлог, түүхэн нөхцөл байдалтай холбоотой юм.

Сонгуульд оролцохыг шаардахыг буруушаах үндэслэл болдог зүйл бол санал өгөх эсэх нь иргэний эрх чөлөө учраас сонгуульд заавал оролцож санал өг хэмээн шаардах нь ардчиллын зарчимд нийцэхгүй хэмээн үзэх юм. Нөгөө талаас сонгуульд заавал оролцохыг иргэдийн албан ёсны үүрэг гэж үзэх хэд хэдэн үндэслэл байдаг. Нэгд, аль болохоор олон сонгогч оролцсон сонгуулийн үр дүнд байгуулагдсан засаг төрийн шийдвэрийн легитимт чанар өндөр

байдаг, хоёрт, ер нь төлөөллийн ардчилал гэдэг бол иргэдийг өргөн хамарсан байх учиртай, гуравт, иргэн сонгуульд оролцох нь түүний улс төрийн боловсролыг дээшлүүлэх нэг арга болдог, дөрөвт улс төрийн намууд авсан саналынхаа тоогоор санхүүжилт авдаг зохицуулалттай нөхцөлд намын албан ёсны санхүүжилт өсөж, ямар нэг бохир санхүүжилт багасах магадлалтай хэмээн үздэг. Улс төрийн амьдралаас харахад сонгуульд оролцож саналаа өгөх, эсэх нь иргэний эрхийн асуудал гээд орхих нь төлөөллийн ардчиллыг утгагүй болгодог тал байна. Тухайлбал, Их Британи улсад болсон Брекситийн гэж нэрлэгддэг тус улс Европын Холбооноос гарах талаар явуулсан санал асуулгын дүнг улс төр судлаачид, улс төрийн философичид ихээхэн шүүмжлэх болсон байна (Grayling A.C. 2021), (Runchimen D. 2019). Грейлинг улс төрчид ард түмний нэрийг барьдаг боловч “ард түмэн” гэдэг бол төөрөгдөл үүсэхэд хүргэдэг нэр томъёо юм гэдгийг дурдаад нарийн яривал тэдний нэрийг нь бариад байгаа нь ард түмэн биш, сонгуульд саналаа өгсөн хүмүүс л юм гэжээ. Тэр бээр улс төрчид ойлголтын тодорхойгүй байдлыг ашиглан хүссэн шийдвэрээ гаргаж байна хэмээн үзжээ. Түүний бичсэн нь: Улс төрийн агуулгаараа бол “ард түмэн” гэдэг нь “санал өгөх эрхтэй хүмүүс” гэсэн утгатай боловч “ард түмэн” ба “хүн ард” (эсвэл “хүн ам”) хоёрын агуулга бүдэг бадаг байдаг нь улстөрчдөд эдгээр нэр томъёог илүү ерөнхий байдлаар ашиглаж, дараах зүйлийг ярих боломжийг олгодог. Хоёр нэр томъёоны хооронд хууль бусаар гулсаж, “санал өгсөн хүмүүсийн дийлэнх” нь гэдгийг нийт хүн амын буюу хүн бүрийг хэлнэ гэсэн сэтгэгдэл төрүүлэх боломж олгож байна.

2016 оны ЕХ-ны бүх нийтийн санал асуулгын дараа Brexit-ийг дэмжигч улстөрчид үүнийг байнга хийдэг байсан; түүнд нийт хүн амын 26% нь ЕХ-ноос гарахын төлөө санал өгсөн ч Brexit-ийг дэмжигч улстөрчид “ард түмэн саналаа хэлсэн”, “Их Британи гарахаар санал өгсөн” гэх мэтээр мэдэгдэв” (Grayling A.C. 2021, 164). Уг санал асуулгад тус улсын сонгуулийн эрхтэй нийт иргэдийн 72,2 хувь буюу 33, 552.983 хүн оролцсоноос 17,410.742 хүн буюу оролцогчдын 51.9 хувь нь тус улсыг УХ-ноос гарахыг дэмжиж, 16,551.983 хүн юу 48.1 хувь нь эсэргүүцсэн байна (BBC. 2021)

Грейлинг дэмжсэн болон эсэргүүцсэн хүмүүсийн хувь ойролцоо байгаа нь хэрвээ оролцоогүй 27.8 хувь нь санал асуулгад оролцсон бол дүн өөр байх магадлалтай байсан гэж үзсэн бололтой юм.

Парламентын болон бусад аливаа сонгууль, санал асуулгын үеэр ийм байдал үүсэж болох бөгөөд энэ нь төлөөллийн ардчиллын үзэл санаатай огт нийцэхгүй юм. Тийм ч учраас сонгуульд заавал оролцож саналаа өгөх журам тогтоох нь төлөөллийн ардчиллыг сайжруулах нэг арга болж болно. Манай оронд ч ийм нөхцөл байдал буй болсныг сонгуулийн үр дүнгийн дээр дурдсан тоо баримтууд харуулж байгаа юм. Хэнд сонгуульд заавал оролцож санал өгөх үүрэг ногдуулах болон парламентад суудал авахын тулд авсан байвал зохих саналын хувь буюу босго ямар байх гэх мэт нарийн ширийн асуудлыг боловсруулах хэрэгтэй болно.

Судлаачдын сүүлийн үед анхаарал хандуулах болсон нэг асуудал бол парламентын гишүүнээр хэн сонгогдож байна вэ гэдэг юм. Төрийн бодлого оновчтой, үр нөлөөтэй байхын

тулд парламентад мэдлэг, чадвартай, туршлагатай, ёс зүйтэй хүнийг олж сонгох нь чухал гэдэг нь ойлгомжтой. Гэвч энэ нь тийм ч амар асуудал биш. Одоогийн нөхцөлд сонгуулийн эрхтэй хүн бүр нэрээ дэвшүүлэх, сонгогдох боломжтой. Тиймээс сонгогдсон хүн бүр дээрх шалгуурт тохирдоггүй нь ойлгомжтой юм. Бүх нийтийн сонгох, сонгогдох эрх болон шилдэг хүмүүс төр барих шаардлага хоёрын хооронд ямагт зөрчилтэй байсан. Бүр Платон энэ асуудалд анхаарлаа хандуулж байсан аж. Тэрбээр бид гутлаа засуулах гэвэл мэргэжлийн сайн гуталчин хэрэгтэй гэж үздэг атлаа хүмүүсийн саналыг авчгаж чаддаг хүн бүр улс юм уу хотыг удирдаж чадна хэмээн үзэж байна хэмээн шүүмжилж байжээ. Улмаар төрийг философичид барих ёстой гэж байсан билээ. Улс төрийн амьдралд эл зөрчлийг шийдвэрлэх гэсэн оролдлого дэлхийн зарим оронд гарч байсан билээ. Тухайлбал, инженер хүн 2, ажилчин 1 санал өгөх эрхтэй, эсвэл хүн олон газар үл хөдлөх хөрөнгөтэй бол тэдгээр газруудад тус бүр нэг санал өгөх эрхтэй байхаар зохицуулж байсан түүх бий. Өнөөдөр хүний улс төрийн эрхийг бүдүүлгээр зөрчсөн ийм зүйл байхгүй. Гэвч зарим хүн Платоны ац асуудал (dilemma) гэж нэрлэдэг эл зөрчил өнөөдөр ч тайлагдаагүй хэвээр байна.

Эл зөрчлийг ямар нэг хэмжээгээр бууруулахын тулд юуны өмнө боловсролын чанарыг дээшлүүлэх, залуу үеийг ажил, амьдралаа авч явах мэдлэг, чадвартай болгохын сацуу эх орны иргэн байх төлөвшлийг бүрэн гүйцэд олгох нь чухал юм. Түүнчлэн нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны нөлөө, байр суурийг дээшлүүлэх хэрэгтэй юм. Хүүхдийг эцэг эх хүмүүжүүлдэг бол

нийгмийг нийгэм-хүмүүнлэгийн ухаан хүмүүжүүлдэг хэмээн хэлбэл бараг болох байхаа. Өнөөгийн дэлхий ертөнцөд ардчилал, хүний эрх, эрх чөлөө гэх мэт либераль үзэл суртлын гол үзэл санааг маш хүчтэй сурталчилж, судалгааны болон хялбаршуулсан ном зохиол тоо томшгүй олон гарч байна. Тиймээс эдгээр үзэл санаанд бараг хэн ч эргэлзэхгүй шахам болжээ. Тэр ч байтугай, огт эсрэг байр суурьтай улс төрийн хүчин хүртэл эдгээр ойлголтыг өөрийнхөөрөө тайлбарлаж, тэдгээрийн төлөө байна хэмээн ярих болсон байна.

Энэ бол нийгэм-хүмүүнлэгийн ухааны нөлөө ямар байдгийг харуулах баримт юм. Б.Даш-Ёндон философитой холбогдуулан «*Социаль философио хөгжлийнхөө бодлогын чиглэлээр нарийвчлан боловсруулж чадаагүй алив бага жижиг улс орны төр засаг нь гуйвамтгай, түмэн олон ядрал задралтай байгааг ажиглаж болно*» хэмээн бичсэнийг нийгмийн ухаанд бүхэлд нь хамаатуулж үзвэл энэ нь иргэдийн төлөвшилд бүү хэл бүх нийтийн зөвшилцөл буй болох хөрс суурийг бэлтгэх нөлөөтэй юм. «*Ийм үед хөгжлийн философи, үзэл баримтлалаа боловсруулах нь монголчууд бидний бүүр хариуцлагатай үйлс болж байна*» (Даш-Ёндон Б.

2019, 33).) Энэ нь хөгжлийн төсөл, хөтөлбөрөөс бүр нарийн асуудлыг хөндөх хэрэгтэй гэсэн үг юм. Үүнд л нийгмийн ухааны учир утга орших биз ээ. Улс орнуудын боловсролын хөтөлбөрт иргэний боловсрол, бусадтай эв санааны нэгдэлтэй, байж, ялгаатай соёл, зан төлөвтэй хүмүүст хүлээцтэй хандаж, хамтран ажиллах чадамжийг төлөвшүүлэх, бусдад энэрэнгүй нигүүлсэнгүй хандаж, тусалдаг иргэдийг төлөвшүүлэх асуудал томоохон байр эзлэх болжээ.

Парламентад нэр дэвшигчдийг үнэлэхэд мэдлэг, чадвараас гадна туршлага гэдэг үзүүлэлтийг харгалздаг байх нь зүйтэй юм. Энэ талаар улс төрийн намууд өндөр хариуцлага хүлээх учиртай. Хүнийг шилж сонгон, улс төрийн тогоонд ямар нэг хэмжээгээр “чанаж”, “болцыг нь гүйцээж” байж нэрийг нь дэвшүүлдэг байх хэрэгтэй. Эсрэг тохиолдолд зүйрлэвэл “туг ширээ атлаа, чөмөггүй” нэр дэвшигчид олширч болох юм.

Эцэст нь дүгнэж хэлбэл, улс орноо хөгжүүлэх бодлого, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд улс төрийн хүрээнд болон иргэдийн улс төрийн соёл боловсролд зарим өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

Ашигласан материал

Цанжид А. 2023. *Шинэ нөхцөл дэх шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого*. Улаанбаатар.

—. 2010. *Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал*. ред. Батболд Су. Улаанбаатар: “Соёмбо принтинг” ХХК.

Trust in government. OECD survey. 2019. <https://www.oecd.org/en/topics/trust-in-government.html>.

Grayling A.C. 2021. *Democracy and Its crisis*. London: Oneworld Publications.

2024. *Carnegieendowment.org*. 02 10. (<https://carnegieendowment.org/europe/strategieurope/2024/02/judy-asks-can-europe-defend-democracy?lang=en>).

Is democracy in crisis?. 2007. *Lse.ac.uk*. 10 22. / [assets/richmedia/channels/public_lectures-AndEvents/transcripts/20071022_Simitis-tr.pdf](https://assets.richmedia/channels/public_lectures-AndEvents/transcripts/20071022_Simitis-tr.pdf).

Cesare Pinelli. 2024. “openaccessgovernment.org.” 02 15. Discussion on the reasons behind the EU’s vulnerability to criticism by populist

- leaders. <https://www.openaccessgovernment.org/article/current-challenges-for-european-democracy/173939/>.
- Selen A. Ercan., Jean Paul Gagnon. 2014. "The Crisis of Democracy: Which Crisis? Which Democracy?" *Democratic Theory*. (Centre for Deliberative Democracy and Global Governance Institute for Governance & Policy Analysis) 1 (2): 1-10.
- Wolfgang Merkel. 2014. "Is There a Crisis of Democracy? ." *Democratic Theory*. (Centre for Deliberative Democracy and Global Governance Institute for Governance & Policy Analysis) 1 (2): 11-25.
- Runchimen D. 2019. *How democracy ends*. London: Profile books.
- Дэмчигдорж Ч. 2002. *Эрдэнэт толь*. Улаанбаатар.
- Durant W. 2006. *The Story of philosophy*. NY: Pocket books.
- J.Toynbee, Arnold. 2001. *A Study of History*.
- Цогц хөгжлийн үндэсний төв. 2020. "gogo.mn." https://gogo.mn/r/1n21m?fbclid=IwAR2dSaa2vbYvquMHUye7fu79GV_BtzSPYfq8YWiqpdeGATr7oBwt4CbvXkg.
- Хатанболд О. 2016. "Монгол Улс дахь төлөөллийн ба шууд ардчиллын харилцан хамаарлын тухай асуудал." *Философи, эрхийн судлал* (XXXI). Философийн хүрээлэн, ШУА. 191-205.
- Батцэрэн У., Хулан Т. 2016. "Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй улс төр, эрх зүй, нийгэм-эдийн засгийн хүчин зүйл, бэрхшээл." *Философи, эрхийн судлал* (XXXI). Философийн хүрээлэн, ШУА. 228-239.
- The Asia Foundation. 2023. *asiafoundation.org*. April. https://asiafoundation.org/wp-content/uploads/2023/04/Mongolia_%D0%9C%D0%9E%D0%9D%D0%93%D0%9E%D0%9B-%D0%A3%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D-%D0%A1%D0%9E%D0%9D%D0%93%D0%A3%D0%A3%D0%9B%D0%AC_Elections-in-Mongolia.pdf.
- Grayling A.C. 2021. *The good state: On principles of democracy*. London: Oneworld Publications.
- BBC. 2021. www.bbc.co.uk. (https://www.bbc.co.uk/news/politics/eu_referendum/results).
- Даш-Ёндон Б. 2019. *Хөгжихүйн философи*. Улаанбаатар. 2019. ред. Чулуунбаатар Г. Улаанбаатар: Философийн хүрээлэн, ШУА, "Соёмбо принтинг" ХХК